МАНАЙ СОНИНЫ II УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,139.536... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.04.26. Лхагва. №082 (4696)

ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ

Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




УЛС ТӨР

Ж.БАТЗАНДАН: Х.НЯМБААТАР АА ЧИ ЯАСАН БАРИВЧЛАХ ДУРТАЙ ХҮН БЭ

II нүүрт

ЦАГ ҮЕ

Х.БАДАМСҮРЭНГИЙН ТАНСАГЛАЛЫН ШАЛТГААН НЬ Ц.НЯМ-ОСОР БАЙЖЭЭ

IV нүүрт

Дугаарын 60 мөр

## Сүржин чуулганаас “даржин” дүн гарах юм

Ж.ОТГОНМЯГМАР

Манай улс уул уурхайн салбараасаа хамгийн их хөрөнгө оруулалтыг олдог. Өөрөөр хэлбэл, уул уурхайгаас хамааралтай орны тоонд зүй ёсоор ордог орон. Уул уурхайн салбараас хамаарал өндөртэй орнуудтай харьцуулахад Монголын эдийн засгийн уул уурхайн салбараас хамаарах хамаарал нэн өндөр байгаа. Энэ нь нэг талаас эдийн засгийн өсөлтийг дэмжих чухал ач холбогдолтой боловч нөгөө талаас эдийн засгийн эмзэг байдлыг бий болгох эрсдлийг дагуулсаар байгааг учир мэдэх хүмүүс хэлдэг билээ. Гэтэл энэхүү амин чухал салбар маань бараг хамгийн хөгждөггүй “дампуу” салбар болж хувираад байна.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

# ХУУЛЬ ХЭРЭГЖИХ СҮРГААР ПРИУСНЫ ҮНЭ “ХАДАНД ГАРЧЭЭ”


Гэрэл зурагийг Г.АРГУУЖИН

Б.СУМЪЯА

Манай улсад бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн дийлэнх нь буюу 75-85 хувь нь 10-аас дээш жилийн насжилттай, хуучирсан техник байна гэсэн судалгааны дүн гарсан байдаг. Тэгвэл энэ сарын 14-ний өдрийн чуулганы хуралдаанаар 2017 оны төсвийг тодотгож Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ хуулийн дагуу долоо хоногийн дараа буюу тавдугаар сарын 1-нээс хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашины татварын хөнгөлөлтийг 50 хувиар бууруулж, суудлын автомашины хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж, насжилтаас хамааруулж онцгой албан татварын хэмжээг нэмэхээр болсон билээ. Тухайлбал, 4500смі-аас доош хөдөлгүүрийн багтаамжтай суудлын автомашинд үйлдвэрлэсэн оноос хамааруулж 3-15 хувь, 4501смі-аас дээш хөдөлгүүрийн багтаамжтай суудлын автомашинд 40-250 хувиар тус тус онцгой албан татварын хэмжээг нэмэгдүүлнэ.

**Үргэлжлэл нь VI-VII нүүрт**

ҮЗЭЛ БОДОЛ

## МАН-ынхан өөрсдийн Засгийн газраа АЖИЛЛУУЛАХГҮЙ БОЛТЛОО ХАГАРЧЭЭ

Б.ТУЛГА

Долоон концессын гэрээг нуун дарагдуулж, Засгийн газрын сайдуудаа хуваагаад өгчихсөн хэрэгт Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат уначихаад байгаа. Өөрөөр хэлбэл, Төсвийн тодотголын үеэр яригдсан 744 тэрбум 90 сая төгрөгийн үнэ бүхий долоон төслийг ямар ямар компани барих, хэнд өгсөн бэ гэсэн улстөрчдийн маргаан нийгмийн анхаарал татсан нэг сэдэв болчихоод байгаа юм. Эдгээр долоон концессоос заримыг нь онцолвол, “Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн агаарын шугам, дэд станц төсөл”, “Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэл”, Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын “Шар тээг”-ийн уулзвараас Цогцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай автозамын төсөл”, “Завхан аймгийн Сонгино сумаас Увс аймгийн Хяргас Зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто замын төсөл”, “Завхан аймгийн Тосонцэнгэлийн дөрвөн замын уулзвараас Нөмрөг, Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай автозамын төсөл, Дархан-Эрдэнэтийн автозамаас Сэлэнгэ аймгийн Сант, Орхон сумын замын зураг төслийг боловсруулах-барих-шилжүүлэх нөхцөлтэй 22.2 км авто зам барих, Нийслэлийн Хан-Уул дүүрэгт 300 ор бүхий төрөх эмнэлэг барих зэрэг дандаа чухал чухал төслүүд байгаа юм. Олон жилийн турш яригдсан, нэг компанийн гэхээс илүү Монгол Улсын хөгжил дэвшил, монголчуудын амьдралд хэрэгтэй том бүтээн байгуулалтын төслүүдийг Засгийн газар хөдөлгөхөөр зориг шулуудсанд нь талархууштай. Концессын гэрээгээр барина гэдэг нь компани эхлээд өөрийн хөрөнгөөр тухайн бүтээн байгуулалтыг хийж дуусгаад дараа нь төрөөс мөнгөө авахаар гэрээ байгуулахыг хэлдэг. Н.Алтанхуягийн, Ч.Сайханбилэгийн удирдсан Засгийн газрууд ч концессийн гэрээгээр маш олон бүтээн байгуулалт хийлгэж байлаа.

**Үргэлжлэл нь III нүүрт**

ОНЦЛОХ МЭДЭЭ



## БНАСАУ их буугаар галлажээ

Б.ДАВАА

БНАСАУ-ын ардын армийн 85 жилийн ой өчигдөр тохиолоо. Ойн баяртай холбогдуулан АНУ, БНХАУ, Япон, БНСУ зэрэг орнууд хамтарсан цэргийн сургуулилт хийж буйн зэрэгцээ Пхеньянд аливаа өдөөн хатгалга явуулахгүй байхыг анхааруулж байсан. Учир нь ардын армийн 85 жилийн ойгоор зургаа дахь удаагийн цөмийн туршилтаа хийж магадгүй гэсэн болгоомжлол бүс нутгийн хэмжээнд үүсээд байсан юм. Түүнчлэн, АНУ-ын “Карл Винсон” довтолгооны хүч ч сургуулилтад оролцохын тулд Солонгосын хойгийн ойролцоо буюу Япон тэнгист байрласан нь олон улсын анхаарлыг татаж байсан. Тэгвэл БНАСАУ цөмийн туршилт хийсэнгүй. Гэхдээ урьд өмнө нь хийж байгаагүй томоохон хэмжээний цэргийн сургуулилт хийжээ. БНСУ-ын эх сурвалжийн Хойд Солонгосын зүүн эргийн Вонсан боомтын ойролцоо хүнд артиллерийн буудлага хийсэн байна. Буудлагын талбайд Хойд Солонгосын удирдагч Ким Чен Ун байлцаж, үзэж сонирхсон гэнэ. 300-400 их буу байсан гэсэн таамгийг ч мөн цэргийн шинжээчид дэвшүүллээ.

Ким Ир Сен агсны мэндэлсний 105 жилийн ой энэ сарын 15-нд тохиож, БНАСАУ цэргийн сүрлэг парад зохион байгуулсан билээ. Мөн өдөр Пхеньян пуужин харваж магадгүй гэж олон улсын хэвлэлүүд мэдээлж байсан удаатай. Гэвч маргааш нь буюу 16-ны өдөр баллистик пуужингийн туршилт хийж байсан юм. Тиймээс ардын армийн 85 жилийн ойгоор биш юм аа гэхэд ойрын үед дахин пуужин харвах магадлал өндөр байгааг эх сурвалжууд онцолж байна.




**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2415.00 | 2429.00 | ФУНТ | 3047.00 | 3141.00 |
| ЕВРО | 2594.00 | 2662.00 | РУБЛЬ | 42.40 | 44.50 |
| ИЕН | 21.90 | 22.22 | ЮАНЬ | 350.00 | 353.450 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2416.00 | 2428.00 | ФУНТ | 3053.00 | 3135.00 |
| ЕВРО | 2595.00 | 2668.00 | РУБЛЬ | 42.13 | 45.42 |
| ИЕН | 21.73 | 22.37 | ЮАНЬ | 350.00 | 353.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Ерөнхийлөгч Дорнод аймгийг “Сүхбаатарын одон”-гоор шагналаа

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Дорнод аймагт ажиллаж, тус аймгийг Төрийн дээд шагнал “Сүхбаатарын одон”-гоор шагналаа. Шагнал гардуулах мөчдөө Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Монголын төр, ард түмний хүндэтгэлийг дорнодчууд Та бүхэнд өөрийн биеэр ирж уламжиллаа. Дорнодчуудад үеийн үед дуурсагдах гайхамшигтай сайхан баяр, түүхэн өдөр тохиож байна. Та бүхний үеийн үед улс орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдал, бүтээн байгуулалтын төлөө зүтгэж ирсэн нөр их хичээл зүтгэлийг Монголын төр үнэлж, дээдийн дээд хүндэтгэлээ үзүүлж байна” хэмээн онцоллоо. Дорнод аймаг нь 74 жилийн өмнө Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнуулж байсан бол өдгөө Сүхбаатарын одонгоор шагнуулж, хос одонтой аймаг боллоо.Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Дорнод аймагт ажиллах үеэрээ Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр гэсэн зүүн болон говийн бүсийн аймгуудын телевиз, сонины сэтгүүлчидтэй мөн уулзалт, ярилцлага хийсэн байна.

БАЙНГЫН ХОРОО

# Ж.БАТЗАНДАН:

# Х.НЯМБААТАР АА ЧИ ЯАСАН БАРИВЧЛАХ ДУРТАЙ ХҮН БЭ

–Гудамжинд нус, цэрээ хаявал 10 мянгаар торгоно–

Ж.ОТГОН



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. Энэ хууль нь нэлээд өргөн цар хүрээг хамарч байгаа тул гишүүд ихэд нухацтай хандаж олон талын байр суурийг илэрхийлэв. Гишүүд торгууль ногдуулах, эрх хасах асуудалд нухацтай хандаж байлаа. Гэхдээ торгуулийн хэмжээг өмнөх хууль зааснаас багасгасан гэдгийг ажлын хэсэг тайлбарлаж байлаа. Торгуулийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцдогийг болиулж, нэгжээр тооцохоор болжээ. Өмнө нь нэг нэгж 2000 төгрөгтэй тэнцдэг байсныг 1000 төгрөг болгохоор төсөлд тусгажээ. Дараагаар нь зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулав. Ажлын хэсгээс “Гудамж талбайд цэр нус хаявал 10 нэгжтэй тэнцэх торгууль ногдуулна. Архи, согтууруулах ундаа хэрэглэхийг зөвшөөрөөгүй газар хэрэглэсэн, мэс зэвсэг биедээ авч явсан бол 25 нэгжээр торгоно. Мансуурсан, аж ахуйн нэгж байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан бол нэжгээд нэгжээр торгох буюу баривчилна. Ингэхдээ албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаанд баривчлах” гэсэн заалт оруулжээ.

Хэлэлцүүлгийн үеэр УИХ-ын гишүүн Ж.Ганбаатар “Эрх хасах тухайд уян хатан хэрэгтэй. Тухайлбал эмч гэхэд 10-15 жил сурсан байхад шууд эрхийг нь хасна гээд байж болохгүй” гэлээ. Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Раднаасэд “Ямар тохиолдолд торгох, тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох, эрхийг нь хасна гэдгээ жагсаалтаар гарга. Тэгвэл илүү ойлгомжтой болно” гэсэн чиглэл өглөө. Харин УИХ-ын гишүүн Н.Оюундарь “Аж ахуй нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг хасдаг болсноор авлига хээл хахууль цэцэглэх шалтгаан болох вий. Тусгай зөвшөөрлийг олгосон этгээд буцаан эргүүлэн татдаг. Гэтэл энэ хуулиар өөр нэг байцаагч очоод эрхийг хаахаар тусгасан байна шүү. Үүний бодолцоорой” гэв. Мөн бэлгийн замын халдварт өвчний тархалт нэмэгдэж байна. Гэтэл хүмүүс оношлуулж, эмчлүүлэхгүй явсаар эрчүүд нь цэрэг татлагын үеэр, эмэгтэйчүүд нь жирэмсний хяналтад орох үеэр илэрч байна. Тиймээс бэлгийн замын халдварт өвчнөө эмчлүүлэхгүй явах, бусдад тараахыг зөрчилд тооцох саналтай байна гэв. Үүний хариуд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Энхбаяр “Эрүүгийн хуулийн төслийн 15.6 дугаар зүйлд бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдол вирус халдаахыг гэмт хэрэгт тооцно гэж хуульчилсан. Өөрөөр хэлбэл Н.Оюундарь гишүүний ярьж байгаа асуудал бол Эрүүгийн хууль тогтоомжоор зохицуулагдсан харилцаа” гэв. Сануулахад, бэлгийн замын халдварт өвчинтэй холбоотой асуудал нь одоогоор албан ёсны хууль болж гараагүй байгаа юм. Эрүүгийн хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэж, баталсны дараа албан ёсоор гэмт хэрэгт тооцогдож, хариуцлага хүлээлгэх аж.

Ажлын хэсгээс оруулж ирсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгах үеэр нийтийн зориулалттай орон сууцанд шөнийн цагаар бусдын амар тайван байдлыг алдагдуулсан бол баривчлахаар заасныг УИХ-ын гишүүн Ж.Батзандан шүүмжиллээ. Тэрбээр “Хуучин энэ тохиолдолд баривчлах бус торгохоор байсан. Наанатай цаанатай хандах хэрэгтэй. Шөнийн цагаар хүүхэд уйлах, зуслангийн байрандаа найз нараа авчраад наргиж цэнгэхэд баривчлагдах нь. Баривчлах байрны чинь багтаамж хүрэлцэх үү, Х.Нямбаатар аа. Монголын цагдаа хуулийг яаж гуйвуулдаг билээ. Чи яасан баривчлах дуртай хүн бэ” гэлээ. Түүний энэхүү шүүмжлэлтэй УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Раднаасэд санал нэг байгаагаа илэрхийлэв. Улмаар санал хураахад дээрх тохиолдолд торгуулахаар болж, хуучин санал хэвээр үлдлээ. Мөн жагсаал цуглаан зохион байгуулахдаа тэсэрч дэлбэрэх бодис, хүний биед аюул учруулах хорт бодис, аливаа зүйл, амьтан авч явсан бол баривчлахаар заасан заалт унаж, торгох заалт хэвээр үлдлээ. Хуулийн төсөлд “Олон нийтийн газар ашиг олох зорилгоор шоо, хөзөр бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан тооцоолох боомжгүй аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом зохион байгуулсан, эсвэл тоглосон бол хүнийг 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан заалтад болгоомжтой хандахыг УИХ-ын гишүүн О.Баасанхүү анхааруулав. Тэрбээр “Зах дээр дартс шидүүлээд, шаар хагалуулж тоглуулдаг тоглоом зөндөө бий. Зургадугаар сарын 1 болоход ийм тоглоом зөндөө гарч ирдэг. Гэтэл одоо энэ хуулиар иргэнийг 500 мянган төгрөгөөр торгох нь. Бараг жилийнх нь орлогоор торгох болж байна. Болж байгаа юм уу. Амьдралтайгаа уялдуулж, хууль хий л дээ. Ажлын байраа өөрөө олоод явж л байгаа тэр хүмүүс хэнд гай болсон юм” гэв. Үүний хариуд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Энхбаяр “Мөрийтэй тоглоомд шаар, дартс зэрэг тоглоом хамаарахгүй. Мөрийтэй тоглоом гэдгийг 2007 онд Улсын дээд шүүхээс тайлбарласан. Тэр тайлбар болох “Шоо, хөзөр, бусад зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан тооцоолох боломжгүй аз туршиж тоглодог тоглоомыг хэлнэ” гэдэг бичилтийг хийсэн байгаа” гэсэн тайлбар өгсөн юм. Харин Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Х.Нямбаатар “Одоогийн Эрүүгийн хуулиар мөрийтэй тоглох гэдэг гэмт хэрэг. Шинэ Эрүүгийн хууль үүнийг гэмт хэрэгт биш гэж тооцоод Зөрчлийн тухай хуульд оруулж ирж байгаа. Олон нийтийн газар ашиг олох зорилгоор шоо, хөзөр бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан тооцоолох боломжгүй аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом зохион байгуулсан эсвэл тоглосон бол гэдэг томъёололд юу горуулж байна вэ гэвэл тоглоомын газар зохион байгуулж байгаа гэдгээ нэг мөр ойлгоё, гэртээ хөзөр тоглож байгаа үйлдлийг бүхэлд нь мөрийтэй тоглож байгаагаас ялгахын тулд олон нийтийн газар гэж ялгасан. Гэртээ найз нөхдөөрөө тоглож байгааг Зөрчлөөр хамаатуулж болохгүй гэж ялгасан юм”хэмээв. Хэвлэл мэдээллийн амыг хамхих бодлого хэмээн нэлээд шүүмжлэл дагуулсан заалт бол УИХ-ын гишүүн Ц.Гарамжавын зарчмын зөрүүтэй санал байлаа. Тэрбээр Зөрчлийн тухай хуулиар гүтгэсэн тохиолдолд хувь хүнийг 10 сая, аж ахуйн нэгжийг 100 сая төгрөгөөр торгох санал гаргаад байнгын хорооны гишүүдээс дэмжлэг авсан юм. Уг нь өмнө нь хувь хүнийг хоёр сая, аж ахуйн нэгжийг 20 сая төгрөгөөр торгох заалттай байсан юм. Хамгийн хачирхалтай нь энэхүү хууль сошиал орчинд хамаарахаар тусгажээ.

### Нялхасын хоол, хүнсний хуулийг өнөөдөр хэлэлцэнэ

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаан өчигдөр 14.00 цагт товлогдсон. Гэвч МУИС-ийн үйл ажиллагаатай танилцаж, дээд боловсролын салбарын бодлого, хууль эрх зүйн орчны талаар санал солилцох болсон тул байнгын хорооныхуралдааныгхойшлууллаа. Тус байнгын хороо өнөөдөр 15.00 цагаас хуралдана. Хурлаар Нялх балчир хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүний тухай / шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл /Монгол Улсын Засгийн газраас 2016.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Цогзолмаа нарын долоон гишүүн өдөр өргөн мэдүүлсэн, төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэх аж.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Монгол, Хятадын зөвлөлийн хуралдаан болно

Монгол, Хятадын эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны зөвлөлийн хуралдаан энэ сарын 24-26-ны өдрүүдэд БНХАУ-ын Бээжин хотноо болж байна. Хуралдаанд тус зөвлөлийн Монголын хэсгийн дарга, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат болон Зам тээвэр, хөгжлийн сайд Д.Ганбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Эрчим хүчний сайд П.Ганхүү болон албаны бусад төлөөлөгчид оролцож байна. Зөвлөлийн нэгдсэн хуралдаан өчигдөр эхэлсэн бөгөөд үүний өмнө Монголын төлөөлөгчид БНХАУ-ын Хөгжил шинэчлэлийн хорооны удирдлагуудтай уулзаж хоёр улсын уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагааны талаар санал солилцжээ.

## Байгаль хамгаалах чиглэлээр Швед улстай хамтрана



БОАЖ-ын сайд Д.Оюунхорол Шведийн вант улсаас Монгол Улсыг хавсран суух Элчин сайд Анна Линдстедийг хүлээн авч уулзлаа. Швед улс нь ногоон бодлогыг нэвтрүүлсэн туршлагатай цөөн орнуудын нэг бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тууштай зогсож, аялал жуулчлалын тогтвортой шийдвэр гаргадгаараа үлгэр жишээ. Уулзалтад Шведийн талаас Бээжин дэх Шведийн ЭСЯ-ны I нарийн бичгийн дарга Якоб Холтхуйс, II нарийн бичгийн дарга Кристер Льюнгвал нар хүрэлцэн ирсэн юм. Уулзалтын эхэнд Д.Оюунхорол сайд “Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн ихээр өртөж байгаа орнуудын нэгд зүй ёсоор орж байгаа. Тиймээс манай яамны зүгээс Монгол Улсыг ногоон бодлоготой улс болгох чиглэлийг баримтлан ажиллаж байна. Энэ хүрээнд бид Парисын хэлэлцээрт нэгдэн, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ногоон төслүүдэд хамрагдах боломжтой болсон. Улаанбаатар хотын хувьд анх зураг төслийг нь 500 мянган хүн амтай байхаар боловсруулсан ч одоо 1.3 сая хүн амьдарч байна. Үүнээс болоод агаар, хөрсний бохирдол дээд цэгтээ хүрсэн. Энэ хүрээнд манай яамны зүгээс санал оруулан холбогдох тогтоолыг Засгийн газраар батлуулан ажиллаж байна. Уул уурхайгаас хараат эдийн засгаа солонгоруулах цаашлаад ногооруулах нь манай яамны эрхэм зорилго. Тиймээс бид бүхэн танай улсын туршлагаас судалж, та бүхэнтэй байгаль хамгаалах, аялал жуулчлалын салбарт харилцаагаа улам өргөжүүлэх хүсэлтэй байна” хэмээсэн юм. Шведийн вант улсаас Монгол Улсыг хавсран суух Элчин сайд Анна Линдстед түүнд өгсөн хариундаа“Танайяамнэгдэнорсон олон улсын гэрээ, хэлэлцээр, хөтөлбөрийнхөө хүрээнд тогтоол, шийдвэр боловруулан маш сайн ажиллаж байна гэж дүгнэж байгаа. Ногоон хөгжил, аялал жуулчлалын бодлогыг эрхэм болгон ажиллаж байгаа танай яамныхантай хамтарч ажиллахад бэлэн байна. Би өөрөө Швед улсын Уур амьсгалын тусгай элчээр ажилладаг тул та бүхнийг холбогдох байгууллагуудтай холбож, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааг дэмжихдээ ямагт таатай байх болно” гэлээ.

ШАР МЭДЭЭ

## АН дотор юм юм л болж байна даа



Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болоход хоёрхон сарын хугацаа үлдээд байна. Улс төрийн нам, улстөрчид дээр, дооргүй л хороо найруулж, Ерөнхийлөгч болох мөрөөдлөөр цалгисаар яваа. Ялангуяа хэт ардчилалтай АН-ын гишүүд аль хэдийн дор бүрнээ Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх сонирхолтой байгаагаа зарлаж, дэгэж дэрвэлзэж, зарим нь бүүр мөрийн хөтөлбөр хүртэл боловсруулчихаад давхиж явна. Уг нь хүчин төгөлдөр үйлчилж буй Сонгуулийн тухай хуульд нэр дэвшигч албан ёсоор тодорсноос хойш, хуульд заасан хугацаанд мөрийн хөтөлбөрөө зарлах учиртай гэнэ. Гэтэл АН-ын улстөрчид “Хэрвээ би Ерөнхийлөгч болвол ийм ажил хийж, ингэж өөрчилнө” хэмээн ярьцгааж байгаа ажиглагчид гайхаж байна. Тухайлбал, Хуульзүйн сайд асан Д.Дорлигжав ойрын үед хэрвээ би Ерөнхийлөгч болчихвол Ерөнхийлөгчийн засаглалтай болгоно. Улс орноо өрнөөс салгаж, бодлогын шинэчлэл хийнэ. Эрс өөрчлөлтийн төлөө энэ биеэ 27 жил бэлтгэлээ хэмээн ярих болов. Өнгөц харахад санал дэвшүүлж байгаа юм шиг харагдавч угтаа энэ бол мөрийн хөтөлбөрийн амлалт. Тиймээс хууль зөрчиж байгаа үйлдэл гэж хэлэхэд буруудахгүй. Мөн нэр дэвшихээр санаархагч Н.Алтанхуяг нар ч энэ мэт мөрөөдлийн мөрийн хөтөлбөрөө ярьж явах юм. Монголоо өөрчилнө, энэ улс орон Ерөнхийлөгчийн засаглалтай болох ёстой л гэнэ. Хатуухан хэлэхэд, энэ мэт тооцоо судалгаагүй зүйл ярьж хийрхэж яваа хүмүүс төрд гарч суучихаад юу хийх бол гэж болгоомжилмоор. Ардчилсан намаас нэр дэвших мандат авахын тулд өнөөх л хуучин зангаараа фракци, фракцийн төлөөлөл нэр дэвшлээ.Дахиад л намын жирийн гишүүдээ фракци болгож хуваачихаад дайтаж гарах нь тодорхой байна. Тэгвэл эх сурвалжийн хэлж буйгаар АПУ-ийн босс нэрээ татахаар болсон дуулдана. Нам дотроо МоАН фракцийг байгуулсан Г.Батхүү нэрээ татаж, МоАН, Нэг ардчиллынхан Лу.Болдыг дэмжихээр болсон гэх бор шувуу нисч буй юм. Энэ мэтээр сунгаа тойрсон үйл явдал эрчимтэй өрнөх нь ээ. АН-д юм юм л болж байна даа.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Б.ӨНӨРТОГТОХ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

# МАН-ЫНХАН ӨӨРСДИЙН ЗАСГИЙН ГАЗРАА АЖИЛЛУУЛАХГҮЙ БОЛТЛОО ХАГАРЧЭЭ



**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Концессын асуудлыг Аж үйлдвэрийн сайдад даатгаж, улмаар баруун замыг нийслэлтэй холбох автозамын ажлыг концессын гэрээгээр хийж байсан жишээ байна. Тэгэхээр энэ өчигдөрхөн л гарч ирсэн шинэ зүйл биш. Ж.Эрдэнэбат гэж нөхөр шинээр сэтгэж, баахан тендерийг хувийн харилцаагаар тараагаад байгаа асуудал огт биш гэдэг нь ч тодорхой. Тухайн бүтээн байгуулалтыг хийхийн тулд "цүнхтэй" компанид тендер өгч болохгүй. Заавал өөрийн гэсэн хөрөнгөтэй, ажиллах хүчин, техник технологийн боломжтой байх шаардлага тулгарна. Өөрийн хөрөнгөөр барьж дуусгаад дараа нь төрөөс мөнгөө авахын тулд цаасан дээр компани байгуулаад ажил авах боломж огтхон ч байхгүй юм. Тиймээс долоон концесс хэн нэг сайдын эсвэл даргын халаас руу орно гэсэн мухар сохор хардлагад итгэх итгэл төрөхгүй нь. МАН-ынхан дотооддоо бужигнаантай, зодоонтой байгаа нь худлаа биш. Ерөнхийлөгчийн төлөөх өрсөлдөөн энэ намд ил далд өрнөж байгаа. Тиймдээ ч Засгийн газрыг муухай харагдуулж/үүний цаана намын даргаа муухай харагдуулах/, оноо авах гэсэн улстөрчид энэ асуудлыг дэвэргэсэн юм биш үү гэсэн хардлага байгааг ч нуугаад яахав. Үнэхээр Ерөнхий сайд хууль зөрчөөд концессыг тараачихсан бол яагаад Ц.Нямдорж гишүүн ганцаараа дуугарав. Өнөөх хүчтэй хэмээн өөрсдийгөө дөвийлгөдөг сөрөг хүчний эсэргүүцэл хаана байна вэ. Засгийн газарт ажиллаж байгаа тэр сайдын компани авлаа гэсэн баттай баримт байхгүй учраас энэ асуудлыг шалгахаар ажлын хэсэг байгуулахад нэг ч гишүүн орохыг хүсээгүй гэнэ лээ. Уул нь төрийн ажил, намын ажил хоёр салангид байх учиртайсан. Гэтэл улстөрчид төрийн ажлыг өөрийн нэр хүндээ өсгөх гэсэн ядмагхан пиартай ашиглаад байгаа учраас монгол төрийн нэр хүнд шалдаа хүртэл уначихаад байгаа юм. Эдгээр долоон концесс дунд өөрийн мөнчгөрөөр, цэвэр өрсөлдөөнөөс ялж гараад тендер авсан компаниуд чамгүй олон байгаа юм билээ. Тухайлбал, өмнөх компани нь өртөг мөнгөө авчихаад хаяад алга болсон Хан-Уул дүүргийн 300 ор бүхий төрөх эмнэлгийн асуудал байна.

Төсөвт өртгөө хэд дахин нэмж орхиод мөнгийг нь идчихсэн компанийн гайг олон мянган ээжүүд үүрсээр байгаа. Төрөхийн орны хүрэлцээгүй байдлаас болж олон мянган ээжүүд эмнэлгийн шалан дээр унтаж, бараг төрж байгаа нь худлаа биш. Гэтэл энэ ажлыг чинь үргэлжлүүлээд өгье хэмээгээд зориг гаргаад орж ирсэн компанийг "Чиний ард хэн нуугдаж байна. Чамайг шалгана аа" хэмээн дарамтлаад байгаа нь хэр зохистой асуудал вэ, улстөрчид өө. УИХ-ын дарга Ц.Нямдорж саяхан хэвлэлд ярилцлага өгөхдөө би цагдаагийн байрыг 10 тэрбумаар бариулж байсан хэмээн ярьчихсан байна билээ. Гэтэл хэдэн зуун ортой, цагдаагийн байрыг хоёр гурав ч нугалахаар том эмнэлгийн байрны өртөг 25 тэрбум байх нь тийм ч хардаж сэрдэж гүйх асуудал биш л байлтай. Ёстой л Ерөнхий сайдын хэлсэнчлэн та нар улс төрөө хийж, Засгийн газар нь ажлаа хийж болдоггүй юм уу. Монгол Улсын эдийн засаг сайнгүй байна. Бүтээн байгуулалт хийнэ гэж зориглох байтугай, компаниа дампууруулахгүй үлдэхийн тулд хаа хаанаа чардайж байна. Төр нь ажил хийх мөнгөгүй. Тийм атлаа ажлыг чинь хийгээд өгье, алдагдалтай байсан ч хамаагүй гээд ороод ирж байгаа компаниудыг цааш нь түлхэх бус харин ч уриалгахан хүлээж аваад ажлыг нь хийлгэвэл зүгээрсэн. Улсын ажил уг нь улс төрөөс ангид байх учиртай бус уу. Засгийн газар ч ялгаагүй. Энэ мэт явган хэрүүл, улстөрчдийн оноо авах гэсэн шоуг үл тоож ажлаа хиймээр байгаа юм. Улстөржиж суусаар байтал улс орны амьдрал хэцүүдлээ. Төрийн ажлаа явган хэрүүлээс болж зогсоохгүй гэж найдъя. Хатуухан хэлэхэд, өнөө цагт концессын гэрээг төртэй хийх компани байгаа нь талархууштай асуудал юм биш үү. Өмнөх компаниуд нь мөнгөө авч чадахгүй жагсаал цуглаах хийхдээ тулж байлаа. Зарим нь ажлаа хийснийхээ төлөө "хэцүү нэрт"-д ачигдах шахсан тохиолдол ч бий.

Зарцуулсан мөнгөө авч чадахгүй дампуурлаа зарлаж байгаа ч компани их байгаа. Тийм байхад энэ ажлыг чинь хийгээд өгье гэж ороод ирэх чадалтай компани байна гэдэг нь олзуурхууштай хэрэг юм. Долоон концессын гэрээг хэлэлцсэн бүлгийн хуралдаан зүгээр ч нэг дэлгэгдээгүй. Үүнийг задлах сонирхол МАН-ын нэр бүхий улстөрчдөд байсан. Зарим нь өөрийнхөө компанийг оруулж чадаагүй учраас хор шар, атаархлаас болж асуудлыг дэврээж байхад нөгөө хэсэгт нь ард түмэнд "гоё" харагдах, оноо авах чухал байсан нь хэнд ч илхэн харагдаж байгаа юм.




Дугаарын 60 мөр

## Сүржин чуулганаас "даржин" дүн гарах юм

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Сүүлийн хэдэн жил улам л уналтанд орж байгаа. Уг нь хөөрхий энэ салбараа хөгжүүлэхчих санаатай уул, уурхайн үндэсний чуулганаас эхлээд уул уурхайн салбарт хөрөнгө оруулалгчдын "Discover Mongolia", уул уурхайн ханган нийлүүлэгчдийн чуулган, олон улсын уул уурхайн хурлууд гээд төрөл төрлийн чуулга уулзалтуудыг хийдэг.

Мэдээж эдгээр чуулга уулзалтуудыг зохион байгуулахын тулд нэлээд их хэмжээний мөнгө хаяж, тус салбарын эрдэмтэн судлаачид төрийн болон төрийн бус байгууллагынхан гээд маш өргөн хүрээнд зохион байгуулдаг юм билээ. Чуулах бүртээ уул уурхайн салбарт тулгамдаж буй асуудал хэтийн зорилгыг хэлэлцэж, маш олон зөвлөмжүүдийг гаргадаг. Эдийн засаг нь уул уурхайн салбараас шууд хамааралтай байгаа өнөө цагт тус салбар луу хөрөнгө оруулагчдын анхаарлыг татах, мөнгөн урсгалыг чиглүүлэхээр оролдож байгаа нь сайн. Гэвч эдгээр төрлийн уулзалтууд бараг үр дүнгүй болчихоод байгаа нь харамсалтай. Тэгсэн хэрнээ төр засаг маань уул уурхайн бүтээгдэхүүний хэлбэлзэл, үнийн өсөлтөд улс орны эдийн засгийн хувь заяагаа даатгаад, хараад суучихдаг гажиг зуршилтай. Эдийн засгаа хэрхэн сэргээх гэхээр улстөрчдийн амнаас нь "Уул уурхайн томоохон төслөө хөдөлгөнө" гэсэн үг л унаж байгаа. Түүнээс биш энэ салбарыг хэрхэн хөгжүүлэх, түүнийхээ төлөө хэрхэн зүтгэх юм гэдэг бодлогын асуудлыг огтоос ярьдаггүй.

Уг нь чуулга уулзалтууд хийгээд байхаар сайжирдаг бол манай улсын уул уурхайн салбарын бүх төрлийн үйл ажиллагаа байгальд ээлтэй хэлбэрт шилжиж ил тод, хариуцлагатай болоод энэ салбар хөгжих гольдролдоо аль хэдийн орчихсон байх учиртай. Гэтэл өнөөх л бахь байдгаараа мөрөөдлөө ярисаар сууна. Нэгэнт энэ салбараас манай улсын хувь заяаа бүрэн хамааралтай байдаг учир уул уурхайн сүржин нэртэй даржин үр дүнтэй чуулга уулзалтуудыг үр дүнтэй л болгомоор байгаа аж. Чуулга уулзалтуудаас гардаг зөвлөмжүүдийн хэрэгжилтийг эргэн хянаж, хариуцлага тооцдог болох гээд жаахан "амьтай" чуулдаг болчихвол яаж байна, уул уурхайн салбарынхаан.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ДУУЛИАНЫ ЭРГЭН ТОЙРОНД

# Х.Бадамсүрэнгийн тансаглалын шалтгаан нь Ц.НЯМ-ОСОР БАЙЖЭЭ


ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2017 оны 03 сарын 03 өдөр Дугаар А/132 Баян-Өндөр су

Автомашин шилжүүлэх тухай

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 1/665 тоот албан бичгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрдэнэт үйлдвэр ХХК-д ашиглагдаж байгаа LEXUS LX-... маркийн 04-05 УНТ улсын дугаартай автомашиныг Автотээврийн ба... үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасаж, Төрийн өмчийн бодлого зох... газрын балансад шилжүүлсүгэй.

2. Дээрх автомашины техникийн бүрэн бүтэн, бэлэн ... хүлээлгэн өгөхийг Автотээврийн байгууллага /Д.Мөнхбаатар/-д үүрэ...

3. LEXUS LX-570 маркийн бүртгэлийн дугаар №5002095 а... компанийн балансаас хасаж, Төрийн өмчийн бодлого зохицуула... шилжүүлэхийг Санхүү, бүртгэлийн хэлтэс /С.Сүхбат/-т зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан компанийн Ерөнхи... 2016 оны 12 сарын 13-ны өдрийн А/788 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Х.БАДАМСҮРЭН







Б.ЭРХЭС

"Эрдэнэт" үйлдвэрийн Ерөнхий захирал Х.Бадамсүрэн ажлаа авснаасаа хойш төрийн мөнгөөр тансаглаж байгаа олон ч баримт ил болоод байгаа. Гэхдээ бүх бурууг түүнд үүрүүлж, золигт гаргах нь тийм ч зөв биш байж магадгүй ч юм шиг. Учир нь "Эрдэнэт" үйлдвэрийн өмнөх захирлын хэрэглэж байсан шинэ "LX 570" машиныг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осорт шилжүүлсэн нь шинэ баримтаар нотлогдлоо. Нэг үгээр, Ц.Ням-Осор өөрөө 570 унахын тулд Х.Бадамсүрэнг Засгийн газрын чиглэлийг зөрчин байж, үйлдвэрийн хөрөнгөөс 300 сая төгрөг гаргуулан шинэ "LX 570" худалдан авахыг нь зөвшөөрчээ. Баримтыг харвал Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 2016 оны арваннэгдүгээр сарын 24-ний өдөр Эрдэнэт үйлдвэрт машин гаргаж өгөхийг шаардсан албан бичиг хүргүүлсэн байна. Энэ нь Х.Бадамсүрэнг үйлдвэрийн Ерөнхий захирлаар томилсон өдөртэй давхцаж байгаа нь энгийн тохиолдол гэхэд бэрх. Ц.Ням-Осор өөрийнхөө хүнийг удирдлагаар томилуулчихаадЖижигБензмашин унаад явж тэсээгүй бололтой. Энэ албан бичгийг үндэслэн "Эрдэнэт" үйлдвэрт ашиглагдаж байсан 0405 УНТ улсын дугаартай "LX 570" маркийн автомашиныг зөвхөн Ерөнхий захирлын гарын үсгээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын балансад шилжүүлжээ. Уг нь бол нэг байгууллагын балансаас нөгөө байгууллагын балансад ийнхүү өмчийг шилжүүлэх нь хууль бус. Харин манай дарга нарт хууль үйлчилдэггүйн бас нэг баталгаа энэ болж байна. Улстөрчдийн шахааны бизнесийн бай, төрийн томчуудын тансаглалын мөнгийг бэлтгэдэг энэ үйлдвэрээс цаашдаа хэчнээн хүн шуналын саваа дүүргэхээр санаархаж, улмаар "Эрдэнэт"-ээс мөнгө идэх явдал даргын машин, байрны тавилгаар дуусахгүй ээ хэмээн таамаглаж бичсэн маань худлаа биш байжээ.

## Ц.Ням–Осорын үг үйлдэл хоёр алд дэлэм зөрөв

Арын албыг нь дааж үлдсэн Ц.Ням-Осор Х.Бадамсүрэнгээс машин "бэлгэнд" авсан нь баримтаар нотлогдчихлоо. Шулуухан хэлэхэд, энэ бол авлига. Тэр тусмаа төрийн өмчийн компанийн өмчийг нэг нэгэндээ бэлэглэлийн байдлаар шилжүүлж болдог хуулийн гаргалгаа хаана ч алга. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор гэх энэ эрхэмд өөрийн бодол, үнэт зүйл гэж байдаггүй бололтой. Угтаа даргын "утсан хүүхэлдэй" хийж, түүнийхээ шагналд машин авсан нь ариун явдал хэрхэвч биш байлтай. Эрдэнэт үйлдвэрийн маргаантай холбоотой асуудал анх яригдаж эхлэхэд Ц.Ням-Осор сэтгүүлчдэд мэдээлэл өгөхдөө "Эрдэнэт үйлдвэрт тансаглал хэрээс хэтэрсэн. Бид олон олон тансаглалыг бууруулж байгаа. Х.Бадамсүрэн даргын цалинг хэд дахин бууруулсан. Би энэ үйлдвэрээс, бас улстөрчдөөс мөнгө огтхон ч аваагүй. Би төрийн шийдвэрийг биелүүлж суугаа энгийн л нэг албан хаагч. Ер нь бол "Төрийн өмчит компаниудын захирлын машин тэрэгний асуудалтай тэмцээд л байгаа юм, яваад л байгаа юм. Овоо гайгүй байсан. Сая Эрдэнэтийн захирал 300 сая төгрөгөөр машин авсан хэрэг гарсан байна лээ" гэж мэдэн будилж байлаа. Гэтэл өөрөө машин авчихаж. Авах, авахдаа авлигаар авчихсан нь баримттай илэрчихлээ. Төрийн өмчийг хувьдаа шилжүүлж, бэлгэнд авснаа тэр нэг ч удаа дурьдаагүй. Үг үйлдэл хоёр зөрнө гэдэг л энэ. Тун саяхан, Ц.Ням-Осор даргад "Эрдэнэт" үйлдвэрийн 49 хувийг эзэмшиж байсан хувийн хэвшлийнхэн шаардлага хүргүүлэхээр очсон юм билээ. Гэтэл эрхэм дарга өрөөнөөсөө гарч ирээгүй гэдэг. Төрийн ажил хийж суугаа албан хаагч хэрвээ мөн юм бол хувийн хэвшлийн шаардлагыг үг дуугүй гардаж аваад цааш нь уламжлах учиртайсан. Харамсалтай түүнд тийм зүрх зориг байсангүй. Угтаа дарга нарын тушаалыг үг дуугүй биелүүлэх "амьгүй албат" төдий гэдгээ л энэ үйлдлээрээ харуулж өгсөн юм. Монгол төрд хариуцлага гэж байх ёстой. Тэр тусмаа төрийн өмчийг ингэж захирлын гарын үсгээр нэгэндээ шилжүүлж байгааг зүгээр хараад суух уу, эрх баригчид аа. Ард түмэн тэнэг биш. Хувийн хэвшлээс хууль зөрчиж дээрэм хийдэг, дээрэмдэж авсан өмчөө нэг нэгэндээ "бэлэглэдэг" гажиг тогтолцоо, гутамшигтай үйлдлийн чинь хариу магад дараагийн сонгуулиар ирэх нь тодорхой. Улс төрийн соёл, хувь хүний үнэт зүйл гэж байдаг бол Ц.Ням-Осор та ард түмнээсээ уучлалт гуй. Төрийн өмчийн байгууллага даргалж суучихаад, нэг үйлдвэрийн эрх ашигт үйлчилж, бас болоогүй улаан цайм худлаа ярьж өөрийгөө өмгөөлсөн үйлдэлдээ тайлбар өгөх цаг нь болсон баймаар. Эрдэнэт үйлдвэрийн эрх ашигт үйлчлэх авлига авснаа ч хүлээн зөвшөөрч, албан тушаалаасаа огцрох ёстой бус уу. Ардчилсан улс орнуудад ийм жишиг олон бий. БНСУ-д гэхэд л найзынхаа компанид илүү эрх мэдэл өгсөн хэргээр Ерөнхийлөгч нь огцорч байна. Гэтэл манайд өөрийн хүнээ даргын суудалд томилж, улмаар машин бэлгэнд аваад л сууж байх жишээтэй. Төрийн өмчийг хоёр хүн хоорондоо албан бичиг шидэлцээд л хольж, сольдог ийм жишиг хэзээнээс тогтсон хэрэг вэ. Эсвэл шахааны бизнесийн хог цуглуулдаг "саалийн үнээ" гэхээрээ юу дуртайгаа хийж болдог юм уу. Эрх барьж буй улс төрийн хүчин энэ асуудлыг шалгах ёстой бус уу.

## Ц.Ням–Осорын тансаглал зөвхөн нэг удаагийнх биш гэнэ үү

"Эрдэнэт"-ээс хувийн хэрэгцээндээ машин гаргуулж байгаа нь Ц.Ням-Осорын хувьд анхных биш гэдгийг тус үйлдвэрийнхэн ярьдаг гэнэ. Өмнө нь "Эрдэнэт" үйлдвэрээс түүний шаардлагын хариуд 2008 оны загварыг гаргаж өгөхөд түлхүүрийг нь буцаагаад шидсэн гэж үйлдвэрийн ажилчид өвөр зуураа жиг жуг хийдэг нь худлаа биш. Тиймээс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын шаардлагаар Х.Бадамсүрэн хөл дүүжлэх унаагүй болж, "аргаядахдаа" 300 сая төгрөгөөр шинэ "LX 570" авч унасан байж болох юм. Хөөрхий даварсан даргадаа хариуцлага тооцож чадахгүй бол ард түмэн та бүхэнд хатуу хариуцлага тооцно гэдгийг сануулах нь илүүц биз. Ер нь төрд ийм буруу жишиг тогтоох хэрэг үү. Даргыг хамгаалдаг, шагналд нь машин авдаг, эсвэл төрийн өмчийн компанийн дарга бүхэн 300 саяар машин авч, 180 саяар байраа тохижуулна гэж барьцвал хэрхэх вэ. Хурган дарга нарынхаа тансаглалыг дийлэхгүйд хүрч, улсын өмчийн хэдэн үйлдвэрүүд чинь модоо барих вий дээ. Төрийн өмчийн бодлогыг зохицуулж суугаа энэ эрхэм "Эрдэнэт"-ээс өөр хэчнээн компаниас машин "бэлгэнд" авсан юм билээ, хэн мэдэхэв. Үүнийг шалгаж тогтоох газар байгаа гэж найдъя. Хэлсэн үг, хийсэн үйлдэл хоёр нь алд дэлэм зөрүүтэй Ц.Ням-Осор Бадмаа даргаас бэлгэнд авсан машинаа юу гэж тайлбарлах нь тун сонин байх нь дамжиггүй.

**Төлбөртэй нийтлэв**

# ОНЦЛОХ ХУУДАС

## Speak out




# ТАТВАРЫН НЭМЭГДЭЛ АРД ТҮМНИЙ НУРУУН ДЭЭРХ АЧААГ УЛАМ НЭМЖ БАЙНА

Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улсын Засгийн газраас долоон төрлийн татварыг шат дараатай нэмж байгаа билээ. Юуны өмнө ирэх сарын 1-ний өдрөөс импортын тамхи, автомашины онцгой албан татварыг нэмж байгаа билээ. Тэгвэл татвар нэмж байгааг иргэд юу гэж бодож буй. Мөн татварын нэмэгдэл иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлж эхэлсэн талаар асууж, байр суурийг нь сонссон юм.

...Хэчнээн тэрбум төгрөг зарж байж жаахан юм хийсэн нь хийсэн л байх. Харин ард түмэнд наалдаж байгаа юм алга. Тун бага л байна. Татвар нэмэгдэх сургаар л иргэдийн амьдралд нөлөөлөөд эхэллээ. Нэг талх авья гэхэд үнэ нэмэгдчихсэн байгаа юм. Тэгэхээр чинь бага, дунд орлоготой иргэдэд хүнд байна биз дээ. Одоо машины үнэ нэмэгдээд эхэллээ. Тэр дундаа монголчуудын дун хэрэглээ болчихоод байгаа приус машины татварыг нэмээд байгааг ойлгохгүй байна...



### Р.Нанжид: Өөрсдийнхөө зардлыг танахгүй байж татвар нэмж байгаа нь буруу

*/Чингэлтэй дүүргийн иргэн/*

-Засгийн газраас татвар нэмэхээр болж байх шиг байна. Эхнээсээ тавдугаар сарын 1-нээс татвар нэмэгдэх талаар зурагтаар ярьж байсан. Татвар нэмэх яах вэ. Нэмэх зүйл дээрээ нэмэлгүй л яахав. Гэхдээ олон татвар нэмснээр мань мэтийн тэтгэврийн хөгшдөөс эхлээд ард түмний амьдралд улам л дарамт болох гээд байна. Дээрээс нь аж ахуйн нэгжүүдэд хүртэл бодит дарамт ирнэ. Ерөөсөө л ард түмэнд дарамт болоод байгаа. Өргөн хэрэглээний барааны үнэ өсч эхэллээ. Цаашлаад машин тэрэг, шатахуун гээд бүхий л зүйлийн үнэ өсөх гээд байна. Би нэг албан байгууллагад харуул хийдэг хүн. Татвар нэмлээ гээд л НӨАТ-гүй байсан чинь авдаг болсон. Цахилгаан бараа зардаг газар л даа. Хуучин нэг барааг 2.4 саяар зардаг байсан бол одоо иргэдийн гар дээр 2.5 саяар очиж байх жишээтэй. Энэ чинь бодит дарамт мөн биз дээ. Тийм болохоор ингэж татварыг хавтгайруулан нэмэх нь буруу. Үгүй ээ, та нар бод доо. Машины үнэ яаж нэмэгдэж байна. Сонин, хэвлэлээр бичсэн байсан. Машины үнэ өч төчнөөн саяар нэмэгдэж байгаа. Татвар нь нэмэгдэж байгаа болохоор машин зарж байгаа хүн үнээ нэмэлгүй яахав дээ. Приус машиныг 14 саяар авдаг байсан гэж бодъё. Гэтэл одоо 16, 17 сая төгрөг болсон байна гэж сонин дээр бичсэн байна билээ. Энэ чинь эргээд л ард түмний амьдралд нөлөөлнө биз дээ. Тийм болохоор би татвар нэмэх асуудалд таатай хандахгүй байгаа. Түүний оронд төсвийнхөө зарлагыг танадаг ч юм уу. Эсвэл энэ томчууд өөрсдийнхөө авдаг цалинг бууруулж яагаад болохгүй гэж. Тэгэхгүй байж татвар нэмээд байгаа нь буруу шүү дээ.



### Ш.Аюуш: Татвар нэмэгдээгүй байхад л бүх зүйлийн үнэ өсөөд эхэллээ

*/Баянзүрх дүүргийн иргэн/*

-Монголын эдийн засаг хүндэрчихсэн. Үүнийг хүн бүр л мэдэрч, харж байгаа байх. Ерөөсөө нүдний өмнө харагдаж байна шүү дээ. Тийм болохоор эдийн засгаа аажим аажмаар сэргээх хэрэгтэй байгаа. Өнөөдөр биш ч гэсэн хэдэн жилийн дараа иргэдэд хэрэгтэй, ядаж л өр зээлээсээ салах болов уу гэсэн бодлоор энэ дарга нар татвар нэмсэн юм болов уу гэж би ойлгоод байгаа. Татвар нэмэхэд хүндрэлтэй байна. Талх тариагаа авахад хүртэл үнэ нь нэмэгдчихсэн байна. Татвар нэмэх асуудалд нэмэгдээгүй байхад нь л бидний амьдралд нөлөөлөөд эхэлчихлээ. Би өөрөө хямдралтай үнэ авдаг, хүнд өвчний оноштой хүн. Гэтэл эм тэдэн хувиар хямдарсан гээд байдаг. Хямдарсан гээд байгаа эмийг нь авахаар өөрчлөлт байхгүй. Эмийн сан ч нь хэдэн мянган төгрөг хямдарсан л гэдэг юм. Би энэ мэт асуудлын учрыг олж чадахгүй л явна. Яваад ч хаачих юм билээ. Хөл хүрэх газар богино болчихсон энэ нийгэмд чинь. Тийм болохоор хүн болгон л дор бүрнээ бодолтой байж, аль болох сайн сайхны төлөө л тэмцэх хэрэгтэй юм уу даа. Тэгээд энэ дарга нар ард түмнийхээ нуруун дээрх ачааг жаахан хөнгөлж, эдийн засгаа дээшлүүлэхийн төлөө ажиллаасай. Сайхан цаг ирэх байх, төр засаг минь өөдлөх байгаа л гэж бодож явна даа.



### Х.Батмөнх: Ядруухан амьдарч байгаа иргэддээ улам л дарамт нэмж байна

*/Сүхбаатар дүүргийн иргэн/*

-ОУВС-гаас зээл авахын тулд аргагүйн эрхэнд татвар нэмэхээр болж байгаа юм болов уу даа. Гэхдээ нэмэхдээ жаахан бодолтой хандах байсан юм. Боломжтой нэгийг нь нэмээд, боломжгүйг нь нэмэх шаардлагагүй шүү дээ. Олон түмний санаа бодлыг сонсоод байхад дээдчүүл нь төсвийн мөнгө хамаагүй зарж үрдэг асуудлаа болиод, зарлагаа танаад явах нь зөв л гэх юм. Би ч бас тэгж бодож байгаа. Ерөөс төрийн бодлого нийтээрээ л буруу байгаа юм. Анхнаасаа буруу явж ирсэн. 20 гаруй жил ард түмэн сайн сайхан болох байх гэж харлаа. Дээрдэж байгаа юм тун цөөхөн байна. Хэчнээн тэрбум төгрөг зарж байж жаахан юм хийсэн нь хийсэн л байх. Харин ард түмэнд наалдаж байгаа юм алга. Тун бага л байна. Татвар нэмэгдэх сургаар л иргэдийн амьдралд нөлөөлөөд эхэллээ. Нэг талх авья гэхэд үнэ нэмэгдчихсэн байгаа юм. Тэгэхээр чинь бага, дунд орлоготой иргэдэд хүнд байна биз дээ. Одоо машины үнэ нэмэгдээд эхэллээ. Тэр дундаа монголчуудын дун хэрэглээ болчихоод байгаа приус машины татварыг нэмээд байгааг ойлгохгүй байна. Яаж сэтгэхээрээ ингэж ажилладаг юм, бүү мэд. Унаа машинтай байж үр хүүхдээ өглөө хүргэж өгч, оройдоо авч байна. Гэтэл хамгийн чухал хэрэгцээ болсон зүйлсийн үнэ нэмэгдээд байна гэдэг ядруухан амьдарч буй иргэддээ улам л дарамт нэмж байна гэсэн үг.



### Г.Энхтуяа: Нийгмийн даатгалын шимтгэлээ ч төлж чадахгүйд тулчихлаа

*/Сүхбаатар дүүргийн иргэн/*

-Ард түмний амьжиргааны төвшин маш муу байгаа. Өдрийнхөө хоолыг яая гэж байгаа хүн Монголд олон бий. Гэтэл төр засгийнхан ямар ч бодлогогүйгээр татвар нэмж байна. Ядаж ямар татвар нэмэх вэ гэдгээ бодолцож үзэх хэрэгтэй. Гэтэл одоо татвар нэмэгдэх сургаар л бүх зүйлийн үнэ өсч байна. Өнөөдөр татвар нэмэгдээгүй байхад л бүхий л барааны үнэ өсч. Би ганцхан хүүхэдтэй, хоёулахнаа амьдардаг хүн. Цалингаас цалингийн хооронд амьдардаг. Нийгмийн даатгалын шимтгэлээ ч төлж чадахгүй байна. Би үсчинд үйлчлэгч хийдэг. 200 мянган төгрөгийн цалинтай. Гэтэл өнөөдөр цалингийн доод хэмжээ 240 мянга болсон. Тийм байхад зарим байгууллагууд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхээр ч цалин өгч чадахгүй л байгаа. Удахгүй нэмнэ л гэсэн. Ард түмэн иймэрхүү л янзтай амьдарч байна. Гэтэл юун татвар нэмэх яриад байна аа.



### Н.Болд-Эрдэнэ: Эко машины татварыг нэмж байгааг ойлгохгүй байна

*/Сүхбаатар дүүргийн иргэн/*

-Нэмэх татвараа нэмдэг л юм байгаа биз. Тэр дундаа хэтэрхий баян, өндөр орлоготой хүмүүсээс авах татвараа нэмэхэд буруу юун. За тэр архи, тамхины онцгой албан татварыг нэмэх яах вэ, байх л ёстой юм. Харин нийгмийн даатгалын шимтгэл нэмэх нь буруу шүү дээ. Албан байгууллагуудад дарамт болно. Мөн машины татварыг хавтгайруулан нэмээд байгааг ойлгохгүй байна. Бусад улсад эко машины татварыг бууруулдаг, бүр авдаггүй гэж сонссон болохоос нэмдэг талаар дуулаагүй юм байна. Гадны улс орнууд татвараа бууруулах талаар ярьж байна л гэх юм. Харин манайх болохоор нэмээд л байгаа. Эдийн засгийнхаа нөхцөл байдалтай холбоотой юм болов уу даа. Татвар нэмэгдээд эхэллээ гэхтэй зэрэгцээд өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдэж байна. Тавдугаар сарын 1-нээс бүр илүү нэмэгдэх болов уу. Гэхдээ би нэг зүйл бодоод байгаа юм. Хуучин машинаас татвар ав. Харин үйлдвэрлэгдээд 4-5 жилийн хугацаанд явсан шинэвтэр машинаас өндөр татвар авахаа больчих л доо. Тэгэхгүй бол олон жил болсон машин манай улсад ирээд, хэдэн жил яваад төмрийн хог болж байна шүү дээ. Энэ асуудлыг татвараар зохицуулж болно. Гэтэл приус мэтийн эко машины татварыг нэмээд сууж байдаг нь жинхэнэ утгаараа харалган шийдвэр л боллоо.

# ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

барааных нь үнэ нэмэгдээгүй тухай учирлаж байхад иргэд хоёр сая хүртэлх төгрөгөөр нэмэгдсэн байгааг онцолж байлаа. Автомашин худалдан авахаар "Да хүрээ" захад зочилж, сонирхсон машиныхаа үнийг асуун, дотор нь сууж үзэж, басхүү доторх эд ангийг нь шинжиж явсан Чингэлтэй дүүргийн иргэн Б.Мөнхбат "Машины үнэ нэмэгдсэн байна. Миний хувьд приус авах санаатай л явна. Өмнөхөөсөө бараг хоёр сая орчим төгрөгөөр нэмэгдсэн байна. Татвар нэмэх сургаар ченжүүд машиныхаа үнийг нэмчихсэн байна шүү дээ. Гэтэл хууль нь хэрэгжиж эхлээгүй байгаа. Ченжүүд нь өөрсдөө автомашиныхааүнийгхөөрөгдөөд



## ПРИУСНЫ "үнэ хаданд гарчээ"



байгаа юм шиг л санагдлаа. Хоёр сарын өмнө ирэхэд, хамгийн үнэтэй приус л 10 сая төгрөг байсан. Гэтэл одоо 12-13 сая төгрөг болсон байна. Сургаар л үнийг нь нэмчихжээ" гэв. Мөн Сонгинохайрхан дүүргийн иргэн М.Сандаг-Очир "Приус 20 маркийн машин сонирхоод явж байна. Үнэ нь нэмэгдчихжээ. Намайг хоёр сарын өмнө ирж, машины үнэ сонирхоход приус 20 машин 10 саятай байсан юм. Гэтэл одоо 12 сая болсон байна. Хамгийн хямд нь л 11 сая болжээ. Нөгөө татвар нэмэгдэх сургаар. Би ч гэсэн л татвар нэмэгдэхээс өмнө машин авчих санаатай явж байна. Татвар нэмэгдвэл машины үнэ ч гэсэн дагаад нэмэгдэх нь ойлгомжтой" гэж ярилаа. Онцгой албан татвар нэмэх хуулийн нэг сөрөг тал нь энгийн бензин, дизель хөдөлгүүрт автомашины онцгой татварыг бараг нэмээгүй гэдгийг зарим судлаачид онцолж байгаа. Ингэснээр зах зээлд дээрх автомашинууд нь хайбридаас хямд болж нийтийн хэрэглээ бензин бага иддэг эко автомашинаас татгалзан есөн жилийн насжилттай энгийн бензин эсвэл дизель автомашин руу бүрэн хэлбийж болзошгүй гэнэ. Учир нь Хайбрид автомашин нь үйлдвэрээсээ өндөр технологи шингэсэн байдаг тул шинэ ч бай хуучин ч бай энгийн машинаасаа үнэтэй байдаг. Хайбрид болон энгийн машин хоёроос яг ижил импортын татвар авбал хайбридын үнэ өндөр болдог. Энгийн машинд 2-3 дахин өндөр татвар ногдуулсны дараа л энэ хоёрын зах зээлийн үнэ ижил төвшинд тогтдог байна.

### "Хоёр хоногийн дараа бүр үнэд орно. Авбал ав"

Ерөнхийдөө автомашины ченжүүд "хямдруулах уу" гэж асуусан иргэдэд "хм. Одоо хоёрхон хоногийн дараа үнэ нь нэмэгдэх гэж байхад одоо авбал ав. Эсвэл үнэд орсных нь дараа авахгүй юу" гэх тоомжиргүй хариулт хэлж буйтай хэд хэдэн удаа таарлаа. Үнийн хувьд мөнгөлөг саарал өнгийн приус 20 маркийн машинууд 2004 оны "S touring" есөн сая 600 мянга, 2007 оны бүтэн жи 10.8 сая, 2008 оны хагас жи 10.4 сая, сувдан цагаан өнгийн приус 20 маркийн машинууд 2004 оны бүтэн жи 11.3 сая, 2008 оны бүтэн жи 11.5 сая, 2005 оны "S touring" 10.8 сая , хар өнгийн 2006 оны S touring 11.5 сая, 2009 оны энгийн 11.5 сая, 2008 оны хагас жи 11.3 сая, 2006 оны энгийн 11.3 сая гэх мэт үнийг хэлж байсан юм.

Яг адилхан он, өнгө, үзүүлэлттэй машинууд иймхүү өөр өөр үнэтэй байгаа нь татвар нэмэгдэх сургаар ченжүүд аманд орсон үнээ хэлж буйн тод жишээ юм. Угтаа ирэх сарын 1-нээс приус маркийн машины 0-3 жил нь 25 мянган төгрөг, 4-6 жил нь 150 мянган төгрөг, 7-9 жил нь 450 мянган төгрөг, 10 дээш жил 1.3 сая төгрөгөөр нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл иргэдийн хамгийн ихээр сонирхож байгаа 2008, 2009 оны приус 20 маркийн машинуудын онцгой албан татвар ирэх сарын 1-нээс 450 мянган төгрөгөөр нэмэгдэх юм. Гэтэл ченжүүд нэмэгдэхээс нь өмнө авах гэсэн иргэдийн эрэлт дээр тоглолт хийж машинуудынхаа үнийг 500 мянгаас нэг сая төгрөгөөр нэмжээ. "Да хүрээ" захад приусны үнэ нэмэгдсэнээс бус, бусад төрлийн газ, бензин хөдөлгүүрт машины үнэ ханш тогтвортой байгааг худалдаа эрхлэгчид ярьж байлаа. Тус захад соната маркийн машин худалддаг эрхэм "Соната маркийн машины үнэ тавдугаар сарын 1-нээс 2.5-3.3 сая төгрөгөөр нэмэгдэнэ. Одоо зургаан сая төгрөгөөр зарж буй машинаа хууль хэрэгжиж эхэлснээс хойш 9-9.5 сая төгрөгөөр худалдаална. Приусны үнэ 0.5-1 сая төгрөгөөр нэмэгдсэн бол соната маркийн машинуудын үнэ ханшинд одоогоор өөрчлөлт ороогүй" гэлээ. Машин сонирхож явсан иргэд ч үнэнд төдийлөн өөрчлөлт ороогүй байна гэцгээж байв. Түүнчлэн, ачааны портер, бонго ачааны машины үнэ харьцангүй тогтвортой байна. Зах зээлийн эрэлт нийлүүлэлтийнхээ хуулиар автомашины үнэ зохицуулагдаж буй бололтой.

### Машин импортлогчид хүндхэн байдалд оржээ

Хууль батлагдахаас өмнө захиалсан хоёр контейнр машиныхаа нэгийг нь 900 ам.доллар нэмж төлөн автомашинаар Замын-Үүдэд хүргүүлсэн нэгэн ченжийн ярилцлагыг дээр дурьдсан. Тэгвэл түүнтэй ижил нөхцөл байдалд орсон маш олон импортлогчид байгаа аж. Өнгөрсөн долоо хоногийн баасан гарагт тэд хэвлэлийн хурал зарлаж, хууль батлагдахаас өмнө захиалагдсан автомашиныг өмнөх хуулийн дагуу тооцохыг шаардсан байдаг. Автомашины онцгой албан татварын нэмэх хуулийг энэ сарын 15-нд баталж, хүчин төгөлдөр болох хугацааг нь тавдугаар сарын 1 гэж заасан билээ. Гэтэл далайд гарцгүй манай орны автомашины бизнес эрхлэгчдийн хувьд хэтэрхий тулсан хугацаа гэдгийг импортлогчид хэлж байна. Тодруулбал, Япон улсаас машин импортолдог анхны компаниудын нэг болох "СБЭТЭ Монголиа" ХХК гэхэд автомашинаа захиалаад, авчрах хүртэл 30-45 хоног зарцуулдаг байна. Гэтэл хууль батлагдахаас өмнө хуучин татвараар тооцон худалдан авалт хийсэн захиалагчдын 2000 гаруй автомашин тавдугаар сарын 1-нээс өмнө хилээр орж ирж амжихгүй болжээ. Ингэснээр анх тохиролцсон үнэ ханш дээр нь үйлдвэрлэгдсэн он, хөдөлгүүрийн багтаамжаас хамааран 375000-5850000 төгрөгийн гэнэтийн тооцоолоогүй нэмэлт татварын дарамт үүсч байгааг учирлаж байлаа.

Мөн бензин зарцуулалт багатай хайбрид машин гэхэд л 2007 оноос өмнөх нь орж ирэх боломжгүй болсны улмаас дээрх захиалгад орсон машинуудын 70 хувь нь татварын хязгаарлалтад оржээ. Шинэ онцгой албан татварын тухай хуулийн дагуу тухайн хязгаарлалтад орсон автомашинд дор хаяж таван сая төгрөгийн зөрүү нэмж төлөх бөгөөд ойролцоогоор 11 саяд ирэх автомашин 16 саяд орж ирэх нөхцөл үүсчээ. Иргэний нэг машинд таван сая төгрөгийн нэмэлт дарамт ирэх юм бол цаашлаад 5-50 машин захиалсан олон тооны бизнес эрхлэгчид хэрхэх вэ. Автомашины ОАТ-ын хуулийг цаг хугацаа олголгүй ямар ч судалгаагүй баталснаас үүдэлтэй татварын зөрүүг хэн хариуцах вэ. Ард иргэд, импортлогч компани уу.

Бид Онцгой албан татварын хууль хэрэгжих хугацааг хойшлуулах, эсвэл урьдчилан захиалсан машинуудад хуучин хуулиар тооцон гаалийн татвар ногдуулах боломжтой эсэхийг Сангийн яамнаас тодруулахад "Хууль тавдугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ. Ерөнхийдөө журамд өөрчлөлт оруулах боломжгүй" гэх тайлбар хэллээ.

Эцэст нь тэмдэглэхэд, автомашины онцгой албан татварын шинэ хууль хэрэгжих сургаар энэ төрлийн бизнесийн зах зээлд савлагаа үүсч эхэлжээ. Тус хуулийн талаар УИХ-ын гишүүн асан Ш.Сайхансамбуу "Тоёота приус машинаас татвар авах нь ард түмний амьдралаас тасарсан, татварын мөнгөөр тоглож суудаг хэсэг бүлэг нөхдөд ашигтай, түмэн олонд хортой маш буруу шийдвэр боллоо. Энэ машин байгальд ээлтэй. Монгол, Японы чөлөөт худалдааны гэрээ бий. Манайх шиг утаагаа шийдэж чадахгүй улсад хамгийн зөв шийдэл болж байгаа. Монголын ард түмний хэрэгцээнд нийцсэн, хотын түгжрэлд шатахуун бага зарцуулна гэх мэт олон сайн тал Тоёота приус машинд бий" гэж сошиал хуудастаа байр сууриа илэрхийлжээ. Хуулийн нэг эерэг тал нь Хайбрид/газ/цахилгаан автомашинаас насжилтийн шатлалаар бага хэмжээний онцгой татвар авдаг болсноор 10-с дээш жилийн насжилттай хайбрид/газ машин орж ирэх боломж нь зах зээлийн хуулиараа багасна. Гэвч, үнэ нь ченжүүдийн цээжний бангаар тодорхойлогдох бололтой.




БАТСҮМБЭРТ 100 ҮНЭЭНИЙ ФЕРМ ЗАРНА





Төв аймгийн Батсүмбэр сумын 324 дүгээр зогсоолын Үдлэг багт байрлалтай 100 үнээний багтаамжтай, өөрийн гүний худаг, 380v цахилгааны эх үүсвэр болон усалгааны системийн хажууд байрлах 7800м2 газартай, 14.2м өргөн, 47м урттай блокоор барьж, тоосгоор өнгөлсөн 64-ийн ханатай, орчин үеийн шийдэлтэй үнээний ферм зарна.

**Үнэ: 200.0 саяас**

**Холбоо барих утас: 99057278**


## Аймгаас мэдээлж байна

СЭЛЭНГЭ АЙМАГ

### Ой хээрийн түймрээс сэрэмжлүүлж байна

Сэлэнгэ аймагт гарч буй ой хээрийн түймэр болон усны ослын ихэнх нь хүмүүсийн өөрсдийн буруутай үйл ажиллагаатай шууд холбоотой гарч байгаа ажээ. Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2017 онд гарсаар Мандал суманд хоёр, Сайхан суманд нэг, Баянгол суманд нэг нийт дөрвөн удаагийн ой, хээрийн түймэр гарсан байна. Мөн гол мөрний ус, мөсөнд цөмөрсөн тохиолдол гурван удаа гарчээ. Эдгээрийг аймгийн Онцгой байдлын газрын албан хаагчид орон нутгийн иргэдтэй хамтран аюулгүй болгож ажилласан байна. Хэдийгээр аймгийн ОБГ-аас ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийн материал тараах, заавар, зөвлөмж өгөх зэргээр урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байгаа ч иргэдийн санамсар болгоомжгүй, хэнэггүй байдлаас болж түймрийн гаралт цаашид нэмэгдэх хандлагатай байгаа аж. Иймээс хаврын хуурайшилттай, салхи шуурга ихтэй цаг улирал ирсэн энэ үед иргэд маш анхаарал болгоомжтой байхыг аймгийн ОБГ-аас онцгойлон анхааруулж, сэрэмжлүүлж байна. **Үүнд:**

- Түлсэн гал, асаасан шүдэнз, татсан тамхины гал, цог, нурмыг бүрэн унтраах.
- Түймэрт нэрвэгдэж болзошгүй нутаг дэвсгэрийг түймрээс хамгаалах зурвастай болгох,
- Түймрийн хуурайшилт ихтэй үед ой, хээрт ил задгай гал түлэхгүй байх.
- Машин, техникийн утааны яндang оч баригчтай болгох.
- Гэр, байшин, малын хашаа, саравч, өвс тэжээл, худгийн эргэн тойронд 100-гаас доошгүй метрийн өргөнтэй цурав / зогоон/ татах, шороон зурвас гаргах.
- Түймрийн аюултай үед айл өрх бүр халуун үнс, нурмыг тусгайлан бэлдсэн таглаа бүхий нүх, саванд хийж байх.
- Насанд хүрээгүй хүүхдийг түймрийн аюултай үед ой, хээрт шүдэнз, асаагуууртай явуулахгүй байх.
- Иргэн, айл өрх бүр гал түймэр унтраах багаж, хэрэгсэлтэй байх, зарлан мэдээллийн дуут дохиотой байх.

Ой хээрийн түймэр гарсан тохиолдолд Онцгой байдлын алба, нутгийн төрийн захиргааны байгууллагад яаралтай мэдээлэх хэрэгтэй. Иргэн та түймэр унтраах ажиллагаанд иргэний үүргийн дагуу оролцох ёстой.

### Өсвөрийн аврагчид ур чадвараа сорилоо

Сэлэнгэ аймгийн сургуулиудын Өсвөрийн аврагч клубуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх, сэтгэл зүй, бие бялдарыг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулагддаг "Өсвөрийн аврагч-2017" тэмцээн гурав дахь жилдээ амжилттай явагдлаа. Тэмцээнд Сүхбаатар сумын ерөнхий боловсролын зургаан сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Спортын бүрэн дунд сургууль, Алтанбулаг, Зүүнбүрэн, Шаамар сумдын ЕБС, Дулаанхаан тосгоны ЕБС, Шаамар сумын МСҮТ зэрэг 13 сургуулийн баг тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Өсвөрийн аврагч тэмцээний нээлтийн ажиллагаанд аймгийн Засаг даргын орлогч Б.Нарантуяа, Онцгой байдлын газрын дарга хурандаа Г.Баатар, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн менежер Н.Баянжаргал нар оролцон хүүхдүүдэд сурлага спортын өндөр амжилт хүссэн юм. Тэмцээнд 10 хүүхдийн бүрэлдэхүүнтэй 13 баг саадтай зурвас, аврах ажиллагаа, эмнэлгийн анхны тусламж, мэдлэг сорих асуулт, гал сөнөөгчийн иж бүрэн хувцас өмсөх зэрэг дөрвөн цэг дээрх өгөгдсөн даалгаварыг биелүүллээ. Тамирчид эдгээр өгөгдлүүдийг гүйцэтгэн нийт дөрвөн км зам туулан өрсөлдсөнөөс багийн дүнгээр Сүхбаатар сумын ЕББД тавдугаар сургуулийн баг тамирчид тэргүүн байр эзэлж, үүрд хадгалагдах цом, өргөмжлөл, алтан медалийн эзэд боллоо. Удаах байруудад Сүхбаатар сумын ЕББД хоёрдугаар сургууль, Дулаанхаан тосгоны ЕББД сургуулийн баг тамирчид тус тус шалгарч шагналын эзэд болов.

ДАРХАН-УУЛ АЙМАГ

### "Өсвөрийн байгаль хамгаалагч" дэд хөтөлбөрийг хэлэлцэв

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний танхим, Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран "Өсвөрийн байгаль хамгаалагч аймгийн дэд хөтөлбөрт иргэдийн саналыг тусгах" сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг боловсролын салбарынхны дунд зохион байгууллаа.Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн дагуу "Өсвөрийн байгаль хамгаалагч" дэд хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд өсвөр залуу үед байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглахад сургах, шинжлэх ухааны мэдээллийг хүргэх нь уг хөтөлбөрийг гол зорилго юм. "Өсвөрийн байгаль хамгаалагч" дэд хөтөлбөрийн хүрээнд нэн тэргүүнд хоёр ЕБС-ыг "ЭКО СУРГУУЛЬ"-ийг бий болгохоор зорьж байна. Мөн ЕБС тус бүрт "Эко зөвлөл" байгуулах бөгөөд ЕБС-иудын ногоон байгууламжийн тоог 50 хувиар нэмэгдүүлэх, сурагчдын экологийн боловсролыг дээшлүүлэх үр дүнг хүлээж байна. Тиймээс сурагчдыг байгаль хамгаалалд оролцуулах, хээрийн аялал зохион байгуулах, өсвөрийн байгаль хамгаалагчдын чуулга уулзалт хийх зэрэг шат дараалсан арга хэмжээнүүдийг авах бөгөөд үүгээр дамжуулан хүүхэд багачуудыг байгаль дэлхийгээ энэрч нигүүлсэгч, хайрлан хамгаалагч болгох, өөрсдөө бүтээж, туршлагаасаа суралцах зарчмаар байгальд ээлтэй, эдийн засгийн хувьд хэмнэлттэй нийгмийн өмнө хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэхээр зорьж байна" хэмээн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга П.Энх-Амгалан ярилаа. Хэлэлцүүлгийн төгсгөлд Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Боловсрол соёл урлагийн газар, Гэр бүл, хүүхэд залуусын хөгжлийг дэмжих газар хамтран дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдэх үйл ажлын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулах ажлын хэсэг байгуулж, дахин хэлэлцэхээр тогтлоо.

## Хүчингүйд тооцов

9011279053 улсын бүртгэлийн дугаартай, 2849739 регистрийн дугаартай "Ди Ти Ди" ХХК-ийн НӨАТ-ын гэрчилгээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

# СПОРТ

ДУУЛГАХ СОНИН

# “Оддын хөлбөмбөг”







# БООЦООТ, ХАЛЗ ТОГЛОЛТ БОЛНО



*Монголын Хөлбөмбөгийн Холбооны маркетингийн хэлтсийн ахлах ажилтан Э.Амарсайхантай ярилцлаа.*

**-Танд юуны өмнө энэ өдрийн мэндийг хүргэе “Хүрхрээ” үндэсний дээд лиг 2017 нээлтийн тоглолтын өмнөх “Оддын хөлбөмбөг” нөхөрсөг, бооцоот халз тоглолт болох талаар мөн “Хүрхрээ” үндэсний дээд лигийн тэмцээний талаар манай уншигчдад мэдээлэл өгнө үү?**

-За баярлалаа. Улсын хэмжээнд зохиогдож буй спортын тэмцээн уралдаануудаас хамгийн өндөр буюу 120 сая төгрөгийн шагналын сантай “Хүрхрээ үндэсний лиг”-ийн тэмцээн энэ сарын 29-нд эхлэх гэж байна. Үндэсний Үйлдвэрлэгч “Арвайн Үндэс” ХХК-тай МХБХ гурав дахь жилдээ хамтран ажиллаж байна. Дөрвөн жилийн хугацаанд нийт 500 сая төгрөгийн гэрээг байгуулсан байдаг. Үндэсний Дээд Лигээс гадна 1-р Лигийг мөн ивээн тэтгэж Монголын хөлбөмбөгийн төлөө жинтэй хувь нэмэр оруулж байгаа үндэсний үйлдвэрлэгч компани юм. Энэ жилийн тэмцээнд Дээд Лигийн шилдэг 10 багт 11 орны нийт 39 гадаадын тоглогчид оролцож байгаа. Энэ нь өмнөх жилүүдийнхээс өссөн үзүүлэлт. Ер нь жил ирэх тусам шагналын сан болон зохион байгуулалтын чанар түүнийг дагаад хөлбөмбөгийг сонирхох сонирхогчид, тоглогчид, үзэх үзэгчдийн тоо нэмэгдсээр байгаа. Энэ жилийн нээлтийг бид өмнөх жилүүдийнхээсээ илүү сонирхолтой, үр өгөөжтэй, илүү гоё болгох үднээс нээлтийн тоглолтын өмнө урлаг соёлын болон спортын алдартнуудаас бүрдсэн “Оддын Хөлбөмбөг”-ийн нөхөрсөг, бооцоот, халз тоглолтыг зохион байгуулж байна. Энэ сард Дэлхийн Аутизмийг таниулах нэг сарын хүрээнд энэ өвчний талаар олон нийтэд зөв мэдээлэл хүргэх, сэтгэл санаагаараа хамт байгаагаа илэрхийлэх, дэлхийн номер нэгт ордог хөлбөмбөгийн спортоор дамжуулан спортынхныгоо энэ хүмүүнлэгийн арга хэмжээ рүү чиглүүлж байгаагаараа онцлогтой юм. “Хүрхрээ” Үндэсний Дээд Лигийн тасалбар өмнөх жилийнхтэй адил 2000 төгрөгөөр худалдаалагдана. Харин нээлтийн өдөр тасалбараа 3000 төгрөгөөр борлуулах бөгөөд тасалбар бүрээс орж буй орлогын 33 хувь буюу 1000 төгрөгийг “Аутизм Монгол Анд” Холбоонд хандивлагдаж, аутизмтай хүүхэд залуучуудын эрүүл мэндэд нь бодит дэмжлэг үзүүлэх зорилготой.

**-“Оддын хөлбөмбөг” халз тоглолтод хэн хэн оролцох вэ тэднийг хэрхэн сонгож багт хуваасан бэ багийг танилцуулна уу?**

-Энэхүү үйл ажиллагааг МХБХ-ноос зохион байгуулан ажиллаж байгаа. Энд МҮОХ-ны ЕНБД, Олимпийн Аварга, Гавьяат тамирчин Бадар-Уган болон ТВ Коктейль хамтлагийн жүжигчин Цолмонбаяр нар маань дэмжиж санаачилга гарган ажиллаж байгаад талархаж байна. “Оддын Хөлбөмбөгт” оролцох тоглогчдыг сонгосон гэхээсээ илүүтэйгээр энэ үйл ажиллагааг дэмжих хүсэлтэй, хөлбөмбөгт бас хорхойтой, Монголын хөлбөмбөгийг дэмжсэн олны танил хүмүүс тэр дундаа соёл урлаг, спортын нэрт зүтгэлтнүүдтэйгээ хамтран ажиллаж байгаа гэвэл зохино. Үндэсний шигшээ багийнхаа өмсгөлүүдээр бэлгэдэж “Хөх”, “Цагаан” багуудад хуваагдана. Хөх буюу “Хөх Чононууд” багийг Олимпийн Аварга, Хөдөлмөрийн Баатар Э.Бадар-Уган ахлах бол Цагаан багийг Олимпийн Аварга, Хөдөлмөрийн Баатар Н.Түвшинбаяр ахлах юм. Ингээд энэ хоёр багт бөхчүүдээс Улсын Арслан н.Пүрэвдагва тэргүүтэй МУ-ын аварга, арслангууд, Х.Цагаанбаатар, Д.Отгондалай нарын тэргүүтэй Тив, Дэлхийн медальтнууд, С.Болд-Эрдэнэ, Э.Цолмонбаяр тэргүүтэй жүжигчид, Guys, Хурдынхан мөн Г.Ганхүү, П.Баярцэнгэл тэргүүтэй “Яг Түүн Шиг” шоуны оролцогчид зэрэг хүмүүс оролцоно. Дасгалжуулагчаар МУСГЗ Ш.Гүрбазар ах маань Хөх Чононууд багийг дасгалжуулан оролцох гэж байна. Мөн багийн эмч, сэтгэлзүйч нараар олны танил гоо үзэсгэлэнт бүсгүйчүүд, Дэлхийд Монголынхоо нэрийг гаргаж буй МИСС охид оролцох болно.

**-“Оддын Хөлбөмбөг”-ийн үеэр өөр ямар нэгэн сюрприз байгаа юу?**

-Байлгүй яахав. Тэр болгоныг дэлгээд яахав, сонирхуулахад тоглолтод оролцож буй эдгээр одод маань өөрсдийн гарын үсэгтэй бөмбөгнүүдийг тараана. Мэдээж тэдэнтэй дурсгалын зураг хамт авхуулах хүсэлтэй үзэгчид, дэмжигчид байгаа байх. Тоглолт маш өрсөлдөөнтэй болно гэдэгт итгэлтэй байгаа. Энэ тоглолтын шагналын сан нийт таван сая төгрөг. Жишээ нь манай ХУРД хамтлагийн гитарчин МУГЖ Отгонбаяр ах маань энэ тэмцээнд зориулж өндөржүүлсэн бэлтгэлд хамрагдаж эхэлсэн байгаагаа хэлсэн. Бүр гурван хоног Бурхан Халдунд сүсэглэн залбирч тэмцээний ёндоогоо дуудах юм гээд бүх талаараа тоглогчид маань бэлтгэлээ базааж байгаа. Мөн хамгийн эхний гоолын эзэн тусгай шагналтай. Тэр нь хэн байх бол. Төгсгөлд нь хэлэхэд дөрөвдүгээр сарын 29-ний бямба гарагийн 13:00 цаг МХБХ-ны хөлбөмбөгийн ногоон талбайд та бүхнийг өргөнөөр хүрэлцэн ирэхийг урьж байна.

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр 19
Шөнө 0

Нөгөөдөр

Өдөр 21
Шөнө 2

## Өдрийн зурхай

**ХАВРЫН ДУНД ХАРАГЧИН ТУУЛАЙ САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ХОНЬ ӨДӨР**

**Аргын тооллын:** 2017.4.26, Лхагва гараг

**Наран ургах шингэх:** 05.43-19.57



*Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр./ Гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олдох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол муу. Нохой уливал амгалан сайн болох, тагнай загатнавал дээрэм ирэх, бие татвал аюул болно. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой.*

## Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

**Oyuka Oyu**

Миний эгч шиг эгч нар зөндөө л байгаа байхдаа эгч намайг гэртээ хүрээд ир миний дүү дүүгээ санаад байна хурдлаарай гээд л урьж зална очингуут мэндийн зөрүүгүй аниа нь ойрхоон гараад ирий за 3дүүгээ хараад л байж байхад болно гэж хувцаслангуутаа сайхан хоол хийчээрэй гэснээ гутлаа өмсөж байхдаа өө тэнд хэдэн хувцас байгаа угаачаарай гээд хаалгаа нээнгүүтээ гэр сайхан цэвэрлээрэй гэнгүүтээ хаалгаа хаахдаа дүү нараа салхилуулаарай тас... найдвартай шөнө 1 2оос нааш ирэхгүй шүү дээ ойрхон гарсан эгч маань хэхэхэ

FOOTBALL NEWS

## “Марсель” Жиругийн төлөө “Арсенал”-д 20 сая фунт төлөхөд бэлэн байна



Английн “Арсенал” клубын довтлогч Оливье Жиру ирэх зуны солилцоо наймааны цонхоор Франц руу буцаж магадгүй байгаа талаар Sky Sports мэдээлж байна. Тус сонины мэдээлж байгаагаар бол Жиру “Марсель” руу буцаж магадгүй байгаа аж. “Марсель” түүний төлөө “Арсенал”-д 20 фунт төлөхөд бэлэн байгаа юм байна. Жиру энэ улиралд премьер лигт 23 тоглолтод оролцохдоо есөн гоол оруулж, дөрвөн гоолын дамжуулалт өгчихөөд байгаа билээ.

СОНИРХУУЛАХАД

## Монголын ТАЕКВОНДОЧИД түүхэн амжилт гаргалаа

Монголын Таеквондочдын амжилтын сайхан мэдээг уншигч таньд дуулгая. Тодруулбал, Казакстан улсын Атарая хотод зохион байгуулагдсан “Kazakh-stan Open” G1 ангилалын чансаа өндөр тэмцээнд Монголын Таеквондогийн үндэсний шигшээ багийн тамирчид маань оролцож буй. Тэгвэл манай тамирчид нэг Алтан медаль, хоёр хүрэл медаль хүртсэн сайхан мэдээг монголчууддаа дуулгалаа. Уг тэмцээнд нийт 37 орны 1700 гаруй тамирчид хүч үзсэн бөгөөд -52кг жинд Б.Намуун Алтан медаль, -68кг жинд П.Тэмүүжин, -74кг жинд А.Нацагдорж нар Хүрэл медаль тус тус хүртжээ. Ингэснээр монголын таеквондогийнхнуудсанднэгэн шинэ түүх бичигдлээ. Тэмцээнд



тамирчдаа амжилттай бэлтгэн оролцуулсан Үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагч Н.Эрдэнэбаатар, дасгалжуулагч багш Ху Иньёон нартаа нийт тамирчдынхаа өмнөөс болон монголчуудынхаа өмнөөс баяр хүргэе. Монголын таеквондогийн тамирчид хэдийнэ дэлхийн энтэй болсон гэдгийг өнгөрөгч 2016 оны зуны олимпийн наадмаас бид харсан. БНСУ-аас мэргэжлийн багшийг урьж, дасгалжуулснаар манай тамирчин П.Тэмүүжин эх орныхоо нэрийг өндөр өргөж, олимпийн наадамд оролцсон билээ.








Нэгэн эмэгтэй Дом-г хүчээр гэмт хэрэгт татан оролцуулж хамгийн дотно хүмүүсийнх нь эсрэг ажиллуулна. Гэр бүл шиг болсон тэд урьд өмнө учирч байгаагүй сорилттой тулгарна.

Аймшигтай ослоос амь гарсан бүсгүйг төгс чадвартай киборг болгон өөрчилж компьютерийн хакеруудын бүлэглэлийн эсрэг илгээнэ.



